



## БОГД БАНКНЫ ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН Д.МОЛОМЖАМЦЫН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Цар тахлын улмаас дэлхий даяар үүссэн хямралын үр дагавар Монгол улсын эдийн засагт, түүний дотор бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгаа хэдий ч Богд банкны удирдлагын зүгээс энэ хүнд нөхцөлд банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах тусгай төлөвлөгөө гарган ажилласны үр дүнд Банкны үйл ажиллагаа энэ оны эхний хагас жилд харьцангуй савалгаа багатай байлаа. Цар тахлын улмаас банкны үйл ажиллагааг тэлэх талаар төлөвлөсөн зорилтуудыг бүрэн хэрэгжүүлэх боломж гараагүй байв. Гэвч Богд банк Монгол улсын зах зээл дээр багагүй үүрэг гүйцэтгэн улсын эдийн засагт хөрөнгө оруулалт хийж, харилцагчийн шаардлагыг хангасан банкны үйлчилгээ үзүүлж байна.

Богд банк 2021 эхний хагас жилд 10 салбар нэгжтэй ажиллаж, тэдгээрт 170 гаруй ажилтан ажиллаж байна. Харилцагчдын тоо 2021 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар 52.8 мянган харилцагчтай болсон ба оны эхнээс 7.8 мянган харилцагчаар нэмэгдсэн байна.

Богд банк нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны гол үзүүлэлтийг ханган ажиллаж байна. Богд банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 50,000,000,000.00 төгрөг байгаа нь Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг биелүүлж байна. Банкны актив хөрөнгө энэ оны 6 сарын 30-ны байдлаар 270,422,424.00 төгрөг болсон нь оны эхнээс 48,008,445.00 төгрөгөөр буюу 21.5 хувиар өссөн байна. Мөн Банкны өөрийн хөрөнгийн хэмжээ 68,326,966.00 төгрөг байгаа нь энэ оны эхнээс 11,2 хувиар өсчээ.

### МОНГОЛ БАНКНААС ТОГТООСОН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	Байвал зохих	Биелэлт
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	>9%	34,91%
Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	>12%	34,91%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	>20%	31,45%
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	<±15%	0,17%
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)	<±30%	0,41%



Монголбанкнаас тогтоосон шалгуур гол үзүүлэлтүүд, тухайлбал, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн активын харьцаа, өөрийн хөрөнгө ба эрсдэлээр жигнэсэн активын харьцаа нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байна. Банкны зээлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, зээлийн чанар өнгөрсөн оноос сайжирсан байна.

2021 оны эхний хагас жилд ТУЗ-ийн хурлууд болон Аудитын хорооны 2 удаагийн, Эрсдэлийн хорооны 2 удаагийн хуралд оролцож, банкны үйл ажиллагааны олон талт асуудлыг зохих журмын дагуу хэлэлцэж, зохих шийдвэрийг гаргаж ирсэн. Эдгээр бүх хуралд хараат бус гишүүний хувьд оролцож, өөрийн байр суурийг илэрхийлж байсан болно.

Хараат бус гишүүний чиг үүргийн дагуу эрсдэлийн болон санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр холбогдох нэгжүүдтэй ойрхон ажиллаж, энэ чиглэлээр ТУЗ болон Банкны удирдлагад зөвлөмж өгч ажиллаж байна. Монголын эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн тогтвортой бус байдлаас улбаалж, цаашид банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох эрсдлийг тогтоож, сэрэмжлэх арга хэмжээ авахад Банкны удирдлагад туслахад ТУЗ-ийн хараат бус гишүүний үүргийн хүрээнд анхаарч байна.

Богд банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээнд энэ хугацаанд өөрчлөлт ороогүй болно. Компанийн тухай хуульд заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгч ажилласан. Мөн Банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн, хууль тогтоомжийг зөрчсөн шийдвэрийг ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын зүгээс гаргаагүй. Аудитын хорооны болон Эрсдлийн удирдлагын хорооны хуралд тогтмол оролцож, хэлэлцэж буй асуудлаар өөрийн саналыг хурлын шийдвэрт тусгуулж байна. Богд банк хувьцаагаа олон нийтэд гаргаж, олон нийтийн компани болох асуудлыг нарийвчлан судалж, энэ талаар бодитой алхам хийх бэлтгэлийг хангаж байна.

БОГД Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн

Д.Моломжамц